



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2011 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А-114

Заавар батлах тухай

"Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.14.1.2 дахь зүйлг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Шинжлэх ухааны, технологийн зөвлөлийн 2011 оны 01 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол орны хэмжээнд цөлжилтийн төлөв байдлын үнэлгээнд ашиглах бэлчээрийн ургамал, хөрсний чанарын анхан шатны үзүүлэлтүүдийг тодорхойлох "Цөлжилтийн хяналт шинжилгээний заавар"-ыг хавсралтаар баталсугай.

2. Цөлжилт, газрын доройтол, газрын хянан баталгааны чиглэлээр улсын хэмжээнд хийж буй бэлчээрийн ургамал, хөрсний чанарын анхан шатны хяналт шинжилгээнд энэхүү зааврыг 2011 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн мөрдөж ажиллахыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдэд зөвлөсүгэй.

3. Бэлчээрийн ургамал, хөрсний чанарын хяналт шинжилгээний ажлын үр дүнг хэвлүүлэх, төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын инженер, техник ажилтнуудад зааж сургах, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний өртөө, харуул, лабораторийн шинжилгээний ажлын хөтөлбөрт нэмж 2011-2012 онд багтаан улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшинд даалгасугай.

4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээнд бэлчээрийн ургамал, хөрсний чанарын хяналт шинжилгээний ажлыг хийхтэй холбогдуулан 10 аймагт Байгаль орчны шинжилгээний лаборатори байгуулах зардлыг 2012 оны төсөвт тусгах арга хэмжээ авахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын дарга Ц.Банзрагч нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат, Цөлжилтийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга Д.Баярбат нарт даалгасугай.

САЙД

Л.ГАНСҮХ



00291